



МОНГОЛ УЛС  
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2024 оны 11 сарын 18 өдөр

Дугаар А/637

Есөнбулаг

Комисс томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1. дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.6, 37 дугаар зүйлийн 37.1.6 дахь заалт, Засгийн газрын 2021 оны "Барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрэм шинэчлэн батлах тухай" 212 дугаар тогтоол, Барилга, хот байгуулалтын сайдын 2021 оны "Барилга байгууламжийн төвөгшлийн ангиллыг зориулалт, хүчин чадлаар нь тогтоох дүрэм батлах тухай" 211 дүгээр тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар баригдсан 2022/123 дугаар гэрээтэй Халиун сумын ундны усан хангамжийн дэд бүтцийн ажлыг хүлээн авч, ашиглалтад оруулах комиссыг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

Комиссын дарга:	Б.Бямбадорж	(Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Барилга, хот байгуулалтын хэлтсийн дарга бөгөөд аймгийн ерөнхий архитектор)
Гишүүдэд:	Н.Долгорсүрэн	("Барилгын хөгжлийн төв" ТӨҮГ-ын барилга байгууламжийн захиалагчийн хяналтын хэлтсийн инженер)
	М.Мандаххүү	(Аймгийн Засаг даргын Тамгын газрын Архивын тасгийн дарга)
	Д.Отгонжаргал	(Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн эрчим хүчний хяналтын улсын байцаагч)
	С.Энхбаяр	(Онцгой байдлын газрын гал түймрийн улсын хяналтын байцаагч, хошууч)
	Г.Золзаяа	(Эрүүл мэндийн газрын эрүүл ахуй, халдвар хамгааллын хяналтын улсын байцаагч)
	Б.Батбилэг	(Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын барилгын техникийн инженер)
	Ц.Ариунжаргал	(Стандарт хэмжил зүйн хэлтсийн хэмжих хэрэгсэл баталгаажуулалтын мэргэжилтэн)

8200011486

2.

Б.Содмаа	(Байгаль орчны газрын Ой, аж ахуй, хүрээлэн буй орчин байгалийн нөөцийн хэлтсийн дарга)
Б.Билгүүндалай	(Орон нутгийн өмчийн газрын хөрөнгийн бүртгэл мэдээлэл хариуцсан мэргэжилтэн)
Ж.Мянганбаяр	(Халиун сумын Засаг дарга)
Ц.Нарангэрэл	(Халиун сумын Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)
Г.Хүрэлхүү	("Ундарга-Алтай" ААТҮГ-ын ерөнхий инженер) (хангагч)
Ж.Мөнхбат	("Алтай-Улиастайн эрчим хүчний систем" ТӨХК-ийн шуурхай ажиллагааны ахлах инженер) (хангагч)
С.Доржзовд	("ЦНТ" ХХК-ийн цэвэр, бохир усны инженер) (зохиогч)
Б.Батбаяр	("Жаргалант дулаан" ХХК-ийн захирал) (гүйцэтгэгч)

Нарийн бичгийн дарга: М.Мөнхцэцэг (Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын инженерийн барилга байгууламж хариуцсан мэргэжилтэн)

2. Инженерийн барилга байгууламжийн угсралтын ажлыг байнгын ашиглалтад оруулахдаа гэрээнд тусгагдсан техникийн нөхцөл, зураг төсөл, холбогдох баримт бичгийн бүрдэлтэй нийцүүлэн шалгаж, хүлээн авч, үр дүнг танилцуулахыг комисс (Б.Бямбадорж)-т үүрэг болгосугай.

3. Холбогдох акт, баримт бичгийг үндэслэн орон нутгийн өмчид бүртгэхийг Орон нутгийн өмчийн газар (Л.Ганхуяг), барилга байгууламжийн урсгал зардлыг сумын төсөвт тусгаж, цэвэрлэх байгууламжийн үйл ажиллагаа хариуцаж албан тушаалтныг томилж, эзэнжүүлж, цаашдын ашиглалт, арчилгаа, хамгаалалтад хяналт тавьж, ажиллахыг Халиун сумын Засаг дарга (Ж.Мянганбаяр), сумын Засаг даргын Тамгын газар (Ц.Нарангэрэл)-т тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА  Г.ЧИНБАТ